



# ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ҮАГ-ГАГ/2016/01-ГА/



*Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн ч зарим ажлын гүйцэтгэл дутуу, бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.*

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
Тэргүүлэх аудитор <b>Т.ОЮУНЧИМЭГ</b>	<b>Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж, үр дүнтэй хэрэгжсэн боловч бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.</b>	
Аудитын менежер <b>Б.ГАНТУЯА</b>	А Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	
Шинжээч <b>Ч.БЭРХСАЙХАН</b>	Б Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	6-17
Шинжээч <b>Т.ЭНХНАРАН</b>	В Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй, зарим ажлын гүйцэтгэл дутуу байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	<b>Бүлэг 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийг зөрчиж баталсан байна.</b> А Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийг зөрчиж баталсан байна. Б Эрх шилжсэн төсөл арга хэмжээ нь худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.	18-20
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	В Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ гэрээний дагуу хэрэгжсэн байна.	
	Дүгнэлт	21
	Дээд шатны байгууллагад хүргэх санал	22
	Зөвлөмж	23
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар	24
	Аудитын газрын тайлбар	25-26
	Тайлан баталгаажуулах тушаал	27-29
	Тайлангийн хавсралтууд	30-41
2016 оны 4 дүгээр сар		

## ТОВЧИЛСОН ҮГС

<b>МУ</b>	<b>МОНГОЛ УЛС</b>
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ЭМСЯ</b>	Эрүүл мэнд спортын яам
<b>ХЗС</b>	Хууль зүйн сайд
<b>БСШУС</b>	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
<b>БХБС</b>	Барилга хот байгуулалтын сайд
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>БСГ</b>	Боловсрол соёлын газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
<b>ХААА</b>	Худалдан авах ажиллагааны алба
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>ТАХ</b>	Төсөл, арга хэмжээ
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/05 дугаар тушаал, Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:** Дундговь аймагт 2015 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх,

**Аудитын зорилтын шалгуур, эх сурвалж болгон ашиглах:** Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглах.

- Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Өмчийн хөрөнгөний тухай хууль,
- Үйлдвэр, ажлаа хөгжүүлэх тухай хууль,
- Концессын тухай хууль
- Өмчийн хөрөнгөний тухай хууль
- Барилгын тухай хууль,
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд,
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”,
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

**Аудитын хамрах хүрээ:** Аудитад Аймаг, нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудад хэрэгжүүлсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулав.

Эрх шилжиж ирээгүй төсөл, арга хэмжээний хувьд ашиглалтын нөхцөл байдлыг тухайн объект дээр очиж, фото зураг авалтаар баримтжуулан, бүртгэл

тайланд тусгасан эсэхийг үндсэн хөрөнгийн тодруулгатай тулган шалгасан.

Эрх шилжиж ирсэн барилгын засварын ажлыг зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг тулган шалгаж, гүйцэтгэлд хэмжилт хийн баримтжуулсан.

Харин барилга байгууламжийн хувьд зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг ажлын гүйцэтгэл тус бүрээр хэмжилт хийх боломжгүй тул түүвэрлэн шалгасан.

**Аудитын арга зүй:** Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг мөрдөн, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, лавлагаа авах, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг аудитын горимуудыг хэрэгжүүлэн, шаардлагатай нотлох баримт цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:** Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг Аудитын менежер Б.Гантуяа хянан удирдаж, Гүйцэтгэлийн аудитын багийн Шинжээч Ч.Бэрхсайхан, Т.Энхнаран нар 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг өөрөөр хугацаанд гүйцэтгэлээ.


#### Ерөнхий мэдээлэл:

2015 онд 4,607.2 сая төгрөгийн 13 төсөл арга, хэмжээ хэрэгжсэн. Үүнээс:

- Он дамжин хийгдсэн 1,398.6 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ,
- Эрх шилжиж ирсэн 515.8 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ,
- Эрх шилжиж ирээгүй 2,692.8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ байна.

Эрх шилжин ирсэн нийт төсөл арга хэмжээний 1,658.7 сая төгрөг буюу 86.6 хувь нь шинээр баригдсан барилга байгууламж, 255.7 сая төгрөг буюу 13.4 хувь нь засварын ажил байна.

Диаграммаар харуулбал:



Дундговь аймагт 2015 онд улсын өөрөөр хугацаанд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг сайдын багцаар харуулбал: БСШУС 10%, ЭМСС 20%, ХЗС 25%, БХБС 7%, Хөдөлмөрийн сайд 38%-ийг эзэлж байна.



ТЕЗ-аас аймаг, сумдын харъяа байгууллагуудад нийт 218.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж хуваарилсан байна. Сайдын багцаар харуулбал:

- ЭМСЯ-аас 97.0 сая төгрөг,
- Хөдөлмөрийн яамнаас 70.8 сая төгрөг,
- БСШУЯ-аас 50.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж хуваарилагдсан байна.

Харин орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6 сумдын ЗДТГ болон аймгийн Цагдаагийн газарт нийт 284.6 сая төгрөгөөр 9 автомашин нийлүүлсэн байна.

*Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж, үр дүнтэй хэрэгжсэн байна.*

*1.А Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн байна.*

Төсвийн тухай 2015 оны хуульд Дундговь аймагт 6,246.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах төсөл, арга хэмжээнүүдийг баталсан байна. Үүнд:

1. YII.1 Цагдаагийн кабон /Баянжаргалан сум/
2. YII.1 Цагдаагийн кабон /Дэрэн сум/
3. YII.4.1.2 Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байр
4. IX.1.1.91 Сургуулийн барилга 320 суудал /Гурвансайхан сум/
5. IX.1.1.143 Цэцэрлэгийн шугам сүлжээ уурын зуухны барилга /Дэрэн/
6. XIY.1.1.4 МСҮТ-ийн хичээл дадлагын байр, спорт заал, 960 суудал
7. XIY.1.1.5 МСҮТ-ийн дотуур байрын барилга, 200 ор
8. XYI.1.1.12 Эмнэлгийн барилга, 10 ор /Адаацаг/
9. XYI.1.1.23 Эрүүл мэндийг дэмжих төв /Сайнцагаан/
10. XYI.1.2.4 Аймаг, сумын эмнэлэг эрүүл мэндийн төвийн байгууллагын их засвар /Өндөршил сумын ЭМТ/

Төсвийн тухай хуульд тусгагдан хэрэгжсэн дээрх 10 төсөл арга хэмжээний 3 нь эрх шилжиж ирсэн, 7 нь эрх шилжиж ирээгүй байна.

Аймгийн БСГ-аас 2015 оны төсвийн төсөлд засварын ажилд 6 санал өгснөөс Хулд сумын сургууль, Өлзийт сумын цэцэрлэгийн засварын ажлуудын 2 санал буюу 33.3 хувь, шинээр барих барилга байгууламжид 7 санал өгснөөс Дэрэн сумын цэцэрлэгийн гадна шугам сүлжээ, уурын зуухны барилгын ажил хийгдэж, өгсөн саналын 14.3 хувь дэмжигдсэн байна. / Хавсралт №2/

Аудитаар нийт төсөл арга хэмжээнүүдийг үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг судалж үзлээ. /Хавсралт №1/

Судалгаагаар нийт төсөл арга хэмжээ нь Улсын болон аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн салбар, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөөтэй уялдсан байна.

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.

Төлөвлөлтийг тайлант онд хийгдсэн 3 засварын ажлын хувьд авч үзлээ. Эдгээр засварын ажлууд нь Төсвийн тухай хуулийн 29.4<sup>1</sup>, Барилгын тухай хуулийн 15.2<sup>2</sup>-д заасны дагуу зураг төсөл нь боловсруулагдсан төсөл арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлсэн байна. /Хүснэгт 1.1/

Хүснэгт-1.1

Д/д	Барилга байгууламж	Зураг төсөв зохиосон огноо	Тайлбар
1	Сургуулийн барилгын засвар /Дундговь, Хулд/	2014	Төсөв батлахаас өмнө зураг төслийг боловсруулсан
2	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Өлзийт/	2014	Төсөв батлахаас өмнө зураг төслийг боловсруулсан
3	Эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Өндөршил/	2014	Төсөв батлахаас өмнө зураг төслийг боловсруулсан

*1.Б Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.*

**Б.1 Худалдан авах ажиллагаа зохион байгуулах бэлтгэл бүрэн хангагдсан байна.**

Тайлант онд аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн, үүнээс 2015 онд шинээр хэрэгжиж эхэлсэн 4 төсөл арга хэмжээний хувьд худалдан авах ажилгааг авч үзлээ. Үүнд:

1. Хулд сумын Сургуулийн барилгын засварын ажил
2. Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын засварын ажил
3. Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил
4. Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт

2015 оны төсвийн хөрөнгөөр Дундговь аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс “Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт”-ын ажлыг ТБОНӨХБАУХА тухай хуулийн 34.1.4<sup>3</sup>-д заасны дагуу гэрээг үргэлжлүүлэн байгуулж, бусад 3 засварын ажлын хувьд төсөвт өртгөөс хамааран нээлттэй

<sup>1</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>2</sup> 15.2.Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно

<sup>3</sup> 34.1.4.нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт болон түүнтэй ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол;

тендер шалгаруулалтын арга ашиглан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. /Хавсралт №3/

Аймгийн ЗДТГ-ын даргын А/02, А/49, А/65 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулжээ.

Үнэлгээний хорооны гишүүдийг томилохдоо ТБОНӨХБАУХАТХ-ийн 47.4<sup>4</sup>-д заасны дагуу байгуулсан байна. /Хүснэгт 1.2/

Хүснэгт-1.2

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Үнэлгээний хорооны гишүүдийн тоо	Салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл	Хувийн хэвшлийн төлөөлөгч	Төрийн бус байгууллагын төлөөлөгч	ЗДТГ-ын ажилтан	ХАА-ны чиглэлээр мэргэшсэн
1	Сургуулийн барилгын засвар /Дундговь, Хулд/	5	1	1	1	3	5
2	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Өлзийт/	5	1	1		3	5
3	Эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Өндөршил/	5	1	1	1	1	5

Дээрх байдлаас харахад эрх шилжүүлэх үйл ажиллагаа болон үнэлгээний хороо байгуулах ажлыг хууль журамд нийцүүлэн үр нөлөөтэй зохион байгуулж, худалдан авах ажиллагаа явуулах бэлтгэл бүрэн хангагдсан байна.

### **Б.2 Худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагдсан байна.**

2015 онд эрх шилжиж ирсэн 341.0 сая төгрөгийн төсөвт өргтөгтэй 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтанд 15 оролцогч оролцож 3 гүйцэтгэгч шалгарч нийт 316.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Аудитаар тендер оролцогчдын материалыг тендерийн баримт бичигт тусгасан шаардлагуудын дагуу дахин үнэлж үзэхэд шалгуур хангасан баримтуудаас үнийн саналаар эрэмбэлэн хамгийн бага үнийн санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулсан нь хууль журамд нийцсэн байна.

Иймд ХААА нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ТБОНӨХБАУХА тухай хуулийн 49.2<sup>5</sup>-д заасан шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэлээ. /Хавсралт №4/.

<sup>4</sup> 47.4-д /Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна./

<sup>5</sup> 49.2.Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ: Үүнд: 49.2.1.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай бол тайлбар; 49.2.2.нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл; 49.2.3.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт



Судалгаанаас харахад тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагуудын /ерөнхий, санхүүгийн, техникийн/ дагуу баримт материалаа бүрэн ирүүлээгүй, шаардлагуудыг хангаагүй 10 оролцогч буюу 66.7 хувь нь тендер шалгаруулалтаас хасагдсан байна.

Аудитаар тендерийн урилга нийтэлж эхэлснээс тендер шалгаруулах хүртэлх хугацааг хууль журамд нийцсэн эсэхийг судалж үзэхэд:

- Тендерийн урилгад тендер хүлээн авах эцсийн хугацааг хуулинд заасны дагуу 30 буюу түүнээс дээш хоногоор тогтоосон.
- Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг тендерийн хүчинтэй хугацаа буюу 45 хоногт багтаан зохион байгуулжээ. /Хүснэгт 1.3/

Хүснэгт-1.3

Д/д	Захиалагчын нэр	Урилга нийтэлсэн огноо	Үнийн санал ирүүлэх хугацаа	Үнийн санал ирүүлэх хоног	Тендер нээсэн огноо	Тендер шалгаруулал сан огноо	Шалгаруулсан хугацаа
1	Сургуулийн барилгын засвар /Дундговь, Хулд/	2015.04.01	2015.05.04	33	2015.05.04	2015.05.07	3
2	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Өлзийт/	2015.04.07	2015.05.08	31	2015.05.08	2015.06.04	27
3	Эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Өндөршил/	2015.01.12	2015.02.12	30	2015.02.12	2015.02.27	15

Судалгаанаас харахад тендер хүлээн авах хугацаа 30-33 хоног, шалгаруулах хугацаа 3-27 хоног буюу нийт 36-58 хоногт багтаан зохион байгуулжээ.

Тендерийн мэдээллийг веб хуудсанд байршуулсан эсэхийг эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хувьд, мэдээллийн самбар байрлуулсан эсэхийг нийт төсөл арга хэмжээний хувьд авч үзэхэд дараах байдалтай байна. /Хүснэгт 1.4/

Хүснэгт-1.4

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Веб хуудсанд байршуулсан эсэх	Самбар байрлуулсан эсэх
1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/		тийм

бичиг; 49.2.4.захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг; 49.2.5.тендерт оролцогчдын ирүүлсэн тендер; 49.2.6.тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж; 49.2.7. тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл; 49.2.8. гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ; 49.2.9. тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг; 49.2.10. гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг.

2	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрын барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан/		тийм
3	Сургуулийн барилгын засвар /Дундговь, Хулд/	тийм	үгүй
4	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Өлзийт/	тийм	үгүй
5	Эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Өндөршил/	тийм	үгүй
6	Гурвансайхан дэд бүтцийн ажлын дуусгалт		үгүй
7	Адаацаг сумын Эмнэлэгийн барилга		үгүй
8	Баянжаргалан сумын цагдаагийн кабон		үгүй
9	Дэрэн сумын цагдаагийн кабон		үгүй
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байр		үгүй
11	Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга		үгүй
12	Дэрэн сумын цэцэрлэгийн гадна уурын зуухны барилга, гадна шугам сүлжээ		үгүй
13	Гурвансайхан сумын 320 хүүхдийн хичээлийн байр		үгүй

Дээрх судалгаанаас харахад ХААА нь тайлант онд шинээр хэрэгжиж эхэлсэн 3 засварын ажлын мэдээллийг e-procurement.mof.gov.mn-д Сангийн сайдын 301 дугаар тушаалын 5.2.2<sup>б</sup>-д заасны дагуу байршуулсан байна.

Аудитын явцад хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх, дуусах хугацаа зэрэг мэдээллийг харуулсан самбар байрлуулсан эсэхийг шалгахад 13 төсөл, арга хэмжээнээс 2 нь буюу МСҮТ-ийн хичээл дадлагын байр, спорт заал, дотуур байрны барилга байгууламжийн гүйцэтгэгч мэдээллийн самбарыг байрлуулжээ.

**Зөрчил 1.1** Харин бусад барилга байгууламжуудын талаарх мэдээллийн самбарыг олон нийтэд үзэгдэхүйц газар ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид байрлуулаагүй байсан. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 46.1.9<sup>7</sup>-д заасныг мөрдөөгүй байна.

Энэ талаар тодруулахад Захиалагч талаас самбар байрлуулахыг гүйцэтгэгч компанид шаарддаг боловч шаардлагыг биелүүлдэггүй. Самбар байршуулаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар хууль, журамд заагдаагүй учраас

<sup>б</sup> 5.2.2 Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Босго үнэ батлах тухай”, Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Цахим сүлжээнд, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ыг тус тус баримтлан тендер шалгаруулалтын зар, үр дүнг худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-нд зарлан мэдээлэх.

<sup>7</sup> ТБОНӨХБАУХАТ хуулийн 46.1.9. /гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах./

шаардлагыг биелүүлэхгүй тохиолдолд дараагийн авах арга хэмжээ байдаггүй гэсэн тайлбарыг өгсөн.

Цаашид гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд ил тод байдлыг хангаж ажиллах, хариуцлагын талаарх заалтыг тусгаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөлөө.

*1.В Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй, зарим ажлын гүйцэтгэл дутуу байна.*

### **В.1 Зарим ажлын гүйцэтгэл дутуу, зураг төсвөөс зөрүүтэй байна**

2015 онд Дундговь аймагт нийт 6,587.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас 4,766.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 12 төсөл, арга хэмжээ тайлант ондоо хэрэгжиж, 131.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжиж байна.

Аудитаар эрх шилжин ирсэн 3-н төсөл арга хэмжээний хувьд гэрээний гүйцэтгэлийг үзэхэд хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гэрээнд заагдсан ажил дутуу хийгдсэн, ашиглалтанд ороогүй байна. /Хүснэгт 1.5/

Хүснэгт-1.5

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээнд заасан хугацаа		Хүлээн авсан огноо	Тайлбар
		Эхлэх	Дуусах		
1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	2014.11.11	2015.12.15	2015.11.09	Ашиглалтанд ороогүй
2	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрын барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан/	2014.08.19	2015.10.01	2015.11.09	Ашиглалтанд ороогүй
3	Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт	2015.06.22	2015.08.22	2015.07.24	Гүйцэтгэл дутуу

Тайлант онд гүйцэтгэж дуусах 6 төсөл, арга хэмжээнүүдийг хугацаанд нь улсын комисс хүлээн авсан боловч ажлын гүйцэтгэл дутуу, ашиглалтанд ороогүй, зураг төсвөөс өөрчлөн гүйцэтгэсэн 4 төсөл арга хэмжээ байна. Өөрчлөгдөн гүйцэтгэсэн ажилд гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулагүй байна. /Хүснэгт 1.6/

Хүснэгт-1.6 /сая төгрөгөөр/

№	Зураг төсвөөр	Төсөв	Гүйцэтгэлээр
<b>МСҮТ-ийн хичээл, дадлагын байр спорт заалны барилга</b>			
1	Уурын зуухны барилга		Өөр компани өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн
<b>Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт</b>			
1	Лагийн талбайн хашааны ажил	38.6	хийгдээгүй
<b>Хулд сумын ЕБС-ийн барилгын засварын ажил</b>			

1	2-р давхар баруун жигүүр математикийн ангийн зүүн вистюлийн 2 гэрлийг ажлын зурагт 2 нэмэх гэрэл тавих		2 хасах гэрэл хийсэн
2	2-р давхар голын коридор хасах гэрэл 7 байх		хасах гэрэл 4 хийсэн, зөрүүг хүлээлгэн өгсөн
3	2-р давхрын зүүн талын коридор 23 хасах гэрэл байх		хасах гэрэл 18 хийсэн
4	Шатны баруун ангийн буцах шугам бүхэлдээ Ф40-ийн ган хоолой тавих		Ф32-ийн ган хоолой тавьсан
5	Ф40-ийн ган хоолой спорт заал хүртэл тавих		Ф32-ийн ган хоолой тавьсан
6	1-р давхрын зүүн коридор хасах гэрэл 10 байна		хасах гэрэл 4 дутууг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн
7	Цонхны чигжээс хийх		Хийгдээгүй өөр ажил хийгдсэн
<b>Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын засварын ажил</b>			
1	Барилгын засварын ажлаар 4 цонх шинээр хийх		2 цонх хийсэн. Төсөв хасагдсан зураг өөрчлөгдөөгүй
2	Дүш трамп хийх		Хийгдээгүй өөр ажил хийсэн
3	Узелийн өрөөнөөс 40Ф ийн ган яндан явах		32Ф-ийн ган хоолойгоор хийсэн
4	32Ф-ийн ган хоолой хийх		25Ф-ийн ган хоолой хийсэн
5	Шатны хоёр талын хананд радиатор угсрах		Аюулгүй байдлыг хангаж өөр газар угсарсан.
6	Цэвэр усны шугамыг 1-р давхараар явуулах		2-р давхараар явуулсан
7	Угаалгын өрөөнд дүш, угаалтуур, трамп хийх		Хийгдээгүй, өөр ажил хийгдсэн
8	00-ийн өрөө эрхлэгчийн өрөөтэй битүү биш байх		Захиалагчийн хүсэлтээр битүүлсэн
9	00 2 тасалгаатай		1 тасалгаатай болгосон
10	2 угаалтуур 2 суултуур		1 угаалтуур, 1 суултуур хийсэн оронд нь өөр ажил хийсэн.

**Зөрчил 1.2** Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт ажлын зураг төсөвт 38.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй лагийн талбайн хашааны ажил хийгдэхээр тусгагдсан боловч тус ажлууд хийгдээгүй, санхүүжилт бүрэн авсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга захиалагчийн дүрмийн 3.1.4. /гүйцэтгэгч нь барилга байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөл, барилгын норм, дүрэм, техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах;/ , Зам,тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт барилгын төсөв зохиох дүрмийн 3-р бүлгийн 3.4 /Барилгын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэнэ. Зураг төслийн дагуу төсвийг, төсөв зохиох үеийн үнээр тодорхойлно. Барилгын төсөв зохиосноос хойш барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаанд материалын үнэ , барилгын өртөгт орсон өөрчлөлтийг тусгасан барилга угсралтын үнийн өсөлтийн батлагдсан индексийг барилгын ажлын гэрээний нөхцөлд нийцүүлэн хэрэглэнэ./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Хийгдээгүй ажлыг дуусгуулахаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

**Зөрчил 1.3** Хулд сумын сургууль, Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын зураг төслөөс өөрчлөгдөн гүйцэтгэсэн ажилд гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулаагүй байна.

Тухайлбал: Хулд сумын сургуулийн засварын ажлын хувьд хүснэгт 1.6-д хийгдээгүй ажлуудын оронд спорт заалны барилгын засварын ажил, заалны үүдний вистюлийн засварын ажил, бусад нэмэлт ажлууд хийгдсэн, Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын хувьд эрхлэгчийн өрөөний засвар, ариун цэврийн өрөөний засвар өөрчлөлтүүд, болон бусад нэмэлт ажлууд хийгдсэн байна.

Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын төсөв өөрчлөгдсөн боловч зураг өөрчлөгдөөгүйтэй холбоотой зарим ажлууд зөрүүтэй байна.

Энэ нь 2015 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.7<sup>8</sup>, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга захиалагчийн дүрмийн 3.1.4<sup>9</sup>, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт барилгын төсөв зохиох дүрмийн 3-р бүлгийн 3.4<sup>10</sup>, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн” журмын 3.3<sup>11</sup> дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Эдгээр зөрчлүүдийг арилгуулахаар холбогдох байгууллага албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлээ.

Уг асуудлуудын талаар ГХБХБГ-аас:

- Хулд сумын сургуулийн барилгын засварын ажлын дутуу хийгдсэн гэрлүүдийг ашиглагч талд хүлээлгэж өгөх,
- Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын дотор халаалтын ажил зураг төсвөөс зөрүүтэй байгааг зургийн дагуу хийх үүрэг даалгаврыг гүйцэтгэгчид өгч хэрэгжилтийг баримтжуулан тайлагнасан байна.

МСҮТ-ийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заалны барилгын ажлын зураг төсөвт Уурын зуухны барилгын ажил багтсан боловч тус ажлыг өөр компаниар гүйцэтгүүлсэн. Үүнийг аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсээс тодруулахад:

<sup>8</sup> 16.7-д /Барилгын ажлын явцад анхны зураг төслөөс өөрчлөгдөж гүйцэтгэсэн үе шатны ажил бүрт гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулна./,

<sup>9</sup> 3.1.4-д /гүйцэтгэгч нь барилга байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөл, барилгын норм, дүрэм, техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах./,

<sup>10</sup> 3.4-д /Барилгын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэнэ. Зураг төслийн дагуу төсвийг, төсөв зохиох үеийн үнээр тодорхойлно. Барилгын төсөв зохиосноос хойш барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаанд материалын үнэ, барилгын өртөгт орсон өөрчлөлтийг тусгасан барилга угсралтын үнийн өсөлтийн батлагдсан индексийг барилгын ажлын гэрээний нөхцөлд нийцүүлэн хэрэглэнэ./

<sup>11</sup> 3.3-д /захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна./



Аймгаас ажлын хэсэг байгуулагдан БСШУЯ, Хөдөлмөрийн яамны холбогдох албан тушаалтануудтай хэлэлцэн:

- Бохир усны өргөх станц, түүний ариутгах татуургын 753 метр урт шугамын ажил барилгын гадна шугам сүлжээний зурагт тусгагдсан боловч төсөвт тусгагдаагүй тул уурын зуухны барилгын 295.0 сая төгрөгийн хөрөнгөөр гадна бохирын шугамын ажлыг хийлгэх

- Аймгийн хот төлөвлөлттэй уялдуулан /аймгийн баруун урд талын байгууллагууд тухайлбал Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Мандал сургуулийн халаалтын асуудлыг нэгтгэн шийдвэрлэх/ уурын зуухны барилгыг орон нутгийн компаний хөрөнгөөр хийлгэх асуудлыг шийдвэрлэсэн байна.

МСҮТ-ийн хичээлийн байр дадлагын байр, спорт заалны барилгын санхүүжилтыг 166.2 сая төгрөгөөр дутуу олгосон. Энэ нь уурын зуух бариулах ажлын санхүүжилт бөгөөд тус барилгыг Дундговь аймгийн Ган-Илч ХХК-тай 2014 оны 02 дугаар сарын 15-ны өдөр гэрээ байгуулан тус компаний хөрөнгөөр бариулсан.

Дээрхи асуудлын талаар хурлын тэмдэглэлд тусгасан боловч албан ёсны тушаал шийдвэр гараагүй, зураг төсөлд өөрчлөлт оруулаагүй байна.

Уг асуудлыг БСШУЯ, Хөдөлмөрийн яамдаас тодруулахаар ҮАГ-т уламжилж байна.

**В.2 Нийт төсөл, арга хэмжээнд хяналт тавьж баримтжуулсан ч ажил бүрт зохиогчийн хяналт хийгдэхгүй байна**

Аудитаар эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнүүдийн хувьд захиалагчийн хяналт хийж баримтжуулсан эсэх, ил далд ажлын акт гаргуулан авч баталгаажуулсан эсэх талаар авч үзлээ. /Хүснэгт 1.8/

Хүснэгт-1.8

№	Төсөл арга хэмжээний нэр	Ил далд ажлын акт боловсруулах ажлын тоо	Ил далд ажлын акт боловсруулан ажлын тоо	Ил далд ажлын актыг захиалагч баталгаажуулсан эсэх	Захиалагчийн хяналт хийж баримтжуулсан эсэх
1	Өндөршил сумын ЭМТ-ийн барилгын засвар	10	3	тийм	тийм
2	Хулд сумын ЕБС-ийн барилгын засвар	4	2	тийм	тийм
3	Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын засвар	5	2	тийм	тийм
4	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	85	85	Хагас ажлыг баталгаажуулаагүй	тийм

5	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрын барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан/	42	42	Хагас ажлыг баталгаажуулагүй	тийм
<b>Нийт</b>		146	134		5

**Зөрчил 1.4** Ажил бүрт ил далд ажлын акт үйлдүүлэн авч баталгаажуулаагүй байна.

Энэ нь 2015 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2<sup>12</sup>, Засгийн газрын 73-р тогтоолоор батлагдсан барилга захиалагчийн дүрмийн 3.1.2<sup>13</sup>, Сангийн сайдын 290-р тушаалаар батлагдсан журмын 3.3<sup>14</sup>, дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж өгөв.

Харин өмнөх аудитаар захиалагчийн хяналтыг тогтмол хийж баримтжуулж байх зөвлөмж өгсөний дагуу нийт төсөл арга хэмжээнүүдэд хяналт хийж баримтжуулсан байна.

Эрх шилжиж ирээгүй төсөл, арга хэмжээнүүдийн хувьд ГХБХБГ-ын захиалагчийн хяналт хийж баримтжуулсан эсэхийг шалгахад нийт 4 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээр гэрээ байгуулж, хяналтыг хийж баримтжуулсан байна./Хүснэгт 1.9/

Хүснэгт-1.9

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Захиалагчийн хяналт хийж баримтжуулсан эсэх
1	Эмнэлэгийн барилга, 10 ор / Адаацаг /	тийм
2	Эрүүл мэндийг дэмжих төв / Сайнцагаан /	тийм
3	Цэцэрлэгийн гадна шугам сүлжээ уурын зуухны барилга / Дэрэн /	тийм
4	Сургуулийн барилга / Гурвансайхан /	тийм

**Зөрчил 1.5** Барилгын засварын ажлуудын хувьд ажил бүрт зохиогчийн хяналт хийгдэхгүй нэгдсэн нэг хяналт хийгдэж байна.

Энэ нь 2015 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3<sup>15</sup>, Барилгын ажилд зохиогчийн хяналт хийх дүрмийн 1.3<sup>16</sup>, Барилга захиалагчийн дүрмийн 3.1.7<sup>17</sup> дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

<sup>12</sup> 15.1.2-д /барилгын ажлын явц, чанарт хяналт тавих, фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах/;

<sup>13</sup> 3.1.2-д /барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, холбогдох бусад баримт бичгийг гүйцэтгэгчээс гаргуулан авах, түүнийг баталгаажуулах;/

<sup>14</sup> 3.3-д /Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна./

<sup>15</sup> 17.1.3-д /энэ хуулийн 15.1.2-т заасны дагуу барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих;/

<sup>16</sup> 1.3-д /Зохиогчийн хяналтыг инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээний угсралт (засвар), хот тосгон, хорооллын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хэмжээг харгалзахгүйгээр заавал хийлгэсэн байна./;

<sup>17</sup> 3.1.7-д /барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх;/

Уг зөрчлийг арилгуулахаар аймгийн ГХБХБГ-т зөвлөмж хүргүүллээ.

### Барилгын хувийн хэрэг хөтлөлт

Тайлант онд хэрэгжсэн нийт 13 төсөл, арга хэмжээнээс 5 байгууллага барилга байгууламжийн хувийн хэрэг нээж хөтөлжээ. Үүнд:

1. Адаацаг сумын ЭМТ-ийн барилга
2. Дэрэн сумын Цэцэрлэгийн уурын зуухны барилга
3. Дэрэн сумын Цагдаагийн кабоны барилга
4. Баянжаргалан сумын Цагдаагийн кабоны барилга
5. Сайнцагаан сумын Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга

**Зөрчил 1.6** Барилга байгууламжийн хувийн хэрэг нээж хөтлөөгүй 8 байгууллага байна. Энэ нь 2015 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1<sup>18</sup>, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх” журмын хавсралт 1-ийн 1.2<sup>19</sup>, 1.3<sup>20</sup> дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Эдгээр зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллага албан тушаалтнуудад албан шаардлага өглөө.

МСҮТ-ийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, МСҮТ-ийн дотуур байрны барилгыг улсын комисс хүлээн авсан боловч барилгуудын халаалтын системийн радиаторууд хөлдөж хагарсан, хананд цав суусан, төсөвт бохир усны ажил тусгагдаагүй, цэвэр, бохир усанд холбогдоогүй, халаалт байхгүй зэрэг шалтгааны улмаас ашиглаж эхлээгүй байна. Хавсралт №5-аар тус ажлуудын зургийг харуулав.

МСҮТ-ийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, МСҮТ-ийн дотуур байрны барилга ашиглалтанд орохгүй удсанаас барилгын чанарт нөлөөлөх, сурагч багш ажилчдын сурах таатай орчин хангагдахгүй байх, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн буурах зэрэг сөрөг үр дагавартай байна. Иймд дээрх асуудлыг холбогдох байгууллагаар шийдүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

### Барилгын баримт бичгийг архивт шилжүүлсэн эсэх

Тайлант онд 12 төсөл арга хэмжээг Улсын комисс хүлээж авсан. Үүнээс 10 байгууллага барилгын баримт бичгийг архивт шилжүүлэн өгч, 2 байгууллага баримт бичгийг архивт шилжүүлээгүй байна. Үүнд:

**Зөрчил 1.7** Баянжаргалан Дэрэн сумдын цагдаагийн кабоны барилга байгууламжийн баримт бичгийг архивт шилжүүлээгүй байна.

Энэ нь 2015 онд мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2<sup>21</sup>-д заасныг зөрчсөн байна.

<sup>18</sup> 21.1-д /Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын тухай төрийн захиргааны төв байгууллагын баталсан журмын дагуу хувийн хэрэг хөтөлнө/

<sup>19</sup> 1.2-т /"Барилгын тухай" хуулийн 3.1.4-д заасан "барилга байгууламж" гэсэн тодорхойлолтод хамаарагдах Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан, бүх төрлийн барилга байгууламжийн /гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын иргэдийн өмчийн болон тэдний мэдлийнхээс бусад/ хувийн хэргийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр заавал хөтөлнө/

<sup>20</sup> 1.3-д /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн ашиглалтын хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогийн талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна./

<sup>21</sup> 21.2-д /Хөрөнгө оруулагч, захиалагч нь ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын гүйцэтгэлийн акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн

Энэ талаар тус ажлуудыг аймгаас хүлээж аваагүй, баримт материалууд нь Цагдаагийн ерөнхий газарт байгаа бөгөөд аймгийн архивт хүлээлгэн өгөх талаар шаардлага тавьсан боловч биелүүлэхгүй байгаа гэж Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн тайлбар өгсөн. Иймд тус 2 барилгын баримт материалыг Аймгийн архивт шилжүүлэх саналыг ЦЕГ-т уламжлахыг Засаг даргад зөвлөсөн.

**НББ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:**

Улсын төсвийн хөрөнгөөр 2015 хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг НББ, шилэн дансанд тусгасан байдлыг шалгахад зарим төсөл арга хэмжээг НББ-д тусгаагүй, дүнг зөрүүтэй тусгасан мөн шилэн дансанд мэдээлээгүй байна. /Хавсралт №4/ Тухайлбал:

**Зөрчил 1.8** Нийт 866.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээг НББ, санхүүгийн тайланд тусгаагүй болон зөрүүтэй тусгасан байна. Үүнд:

- Адаацаг сумын ЭМТ-ийн 861.1 сая төгрөгийн өртөгтэй барилгыг санхүүгийн тайланд 861.0 сая төгрөгөөр буюу 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.
- ЭМСЯ-аас Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр сумдад нийлүүлэгдсэн нэг бүр нь 0.6 сая төгрөгийн үнэтэй 3 ширхэг буюу нийт 1.8 сая төгрөгийн цусны даралтын аппарат,
- Дэрэн сумын цэцэрлэгийн 305.0 сая төгрөгийн өртөг бүхий уурын зуухны барилга,
- Өндөршил сумын ЭМТ-ийн 70.0 сая төгрөгийн өртөгтэй барилгын засварын ажлыг тус тус бүртгээгүй,
- МСҮТ-ийн 6,286.2 сая төгрөгийн хичээл дадлагын байр, дотуур байрны барилгыг бүртгэлд 5,796.4 сая төгрөгөөр дуусаагүй барилга байгууламжид бүртгэсэн байна.

Эдгээр зөрчлүүдийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлээ.

❖ Хөрөнгө оруулалтын нийт 10,706.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна. /Хавсралт №6/

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.2.4<sup>22</sup>, 6.3.7<sup>23</sup>, 6.4.3<sup>24</sup>-дахь заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар байгууллагуудын холбогдох албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

зураг, барилгын ажлын чанар, явцад зохиогч болон мэргэжлийн хяналт гүйцэтгэгчийн дүгнэлт, ашиглалтад хүлээлгэн өгсөн баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 1 сарын дотор холбогдох архивт шилжүүлнэ./

<sup>22</sup> 6.2.4-д /хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт;/

<sup>23</sup> 6.3.7. /хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;/

<sup>24</sup> 6.4.3./тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;/

*Бүлэг 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг баталсан нь Төсвийн тухай хуулийг зөрчиж байна.*

*2.А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийг зөрчин баталсан байна.*

Аймгийн ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 05-ны 11 дүгээр тогтоолоор Орон нутгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн нөөц хөрөнгө нэрээр 157.5 сая төгрөгөөр баталсныг 2015 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01 дугаар тогтоолоор 132.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 290.0 сая төгрөг болгон хуваарилагдаагүй нөөц хөрөнгө нэртэйгээр баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 56.2-т /Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ/, 4.1.30-д /“орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж энэ хуулийн 58.1.1, 58.2.1, 58.3.1, 58.4.1-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, энэ хуулийн 58.1.4, 58.1.14, 58.2.4, 58.2.13, 58.3.2, 58.3.5, 58.4.2, 58.4.6-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал зарлагын нийлбэрийг/, 60.2.3-т /Энэ хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг/ гэж заасны дагуу Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх ёстой. Үүнийг хэрэгжүүлэхээр өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар болон бусад аудитуудаар зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлэхгүй орон нутгийн хөрөнгө оруулалт гэж баталсаар байна. Орон нутагт төсвийн төсөл өргөн мэдүүлдэг, баталдаг эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй байдал газар авах хандлагатай болоод байна. Иймд уг асуудалд анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

Дээрх төсөл, арга хэмжээ нь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч орон нутагт зайлшгүй хэрэгцээтэй зүйлд зарцуулагдсан гэсэн тайлбарыг холбогдох албан тушаалтнууд өглөө.

*2.Б Эрх шилжсэн төсөл арга хэмжээ нь худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.*

Дундговь аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Тээврийн хэрэгслийн зориулалтын бусад хөрөнгийн зардлаар хийгдэх ажлын жагсаалт батлах тухай” А/101 дугаар захирамжаар нийт төсөвт өртгийг

1. Жип болон УАЗ төрлийн автомашин 2ш 75 сая,
2. УАЗ төрлийн автомашин 6ш 205 сая,
3. Жижиг оврын автомашин 1ш 10 сая төгрөгийн гэж 3-н багц болгон баталсан байна.



Эдгээрээс багц 1 буюу Жип болон УАЗ төрлийн 75 сая төгрөгийн 2 ширхэг автомашиныг Дундговь аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/382 дугаар захирамжаар Сайхан-Овоо сумын Засаг даргад эрх шилжүүлж, Багц 2, 3-ын тендер шалгаруулалтыг аймгийн ХААА зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт-2.1

Төсөл арга хэмжээний нэрс	Батлагдсан төсөв /мянган төгрөг/	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам
Жип болон УАЗ төрлийн автомашин	75,000.0	Харьцуулалт
УАЗ төрлийн автомашин	205,000.0	Нээлттэй
Жижиг оврын автомашин	10,000.0	Шууд худалдан авалт

Багц-2-ын худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдсөн. Уг тендерт нийт 2 оролцогч тендер ирүүлсэнээс 1 оролцогч нь тендерийн баримт бичигт заасан шаардлага хангаж гэрээ байгуулах эрх авсан. Гэрээ байгуулах эрх олгосноос хойш 1 хоногийн дараа буюу хуулинд заасан хугацаанд багтааж гэрээ байгуулжээ.

Аудитаар Багц-2 тендерт оролцогчдын /2/ баримт материалыг тендерийн шаардлагуудын дагуу дахин үнэлж үзэхэд шалгуурыг хангасан байлаа. Тендерийн дахин үнэлсэн судалгааны дэлгэрэнгүйг хавсралт №4-т харуулав.

Багц-3-ын худалдан авах ажиллагааны журмын дагуу босго үнэд үндэслэн шууд худалдан авалт хийгдсэн байна.

**Зөрчил 2.1** Багц-1-ийн худалдан авах ажиллагааг Сайхан-Овоо сумын Засаг даргын байгуулсан үнэлгээний хороо зохион байгуулсан бөгөөд нийт төсөвт өртгийг үндэслэхгүй багц болгон багцын төсөвт өртгийг үндэслэн харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д /Захиалагч энэ хуулийн 8.6-д зааснаар тендер шалгаруулалтыг багцад хувааж явуулахдаа дараах шаардлагыг хангана/, 8.7.1-д /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/ гэж заасныг, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68-р тогтоолыг тус тус зөрчсөн байна. Уг алдаа зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх талаар Сайхан-Овоо сумын Засаг даргад албан шаардлага, зөвлөмж өгч ажилласан.

Цагдаагийн газар болон 6 сумын нийт 9 автомашины төсөвт өртөг 290,000.0 мянган төгрөг батлагдсанаас 284,589.8 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан байна.

**2.В Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ гэрээний дагуу хэрэгжсэн байна.**

Гэрээний гүйцэтгэл, хэрэгжилт

Орон нутгийн төсвийн хөрөнгөөрх 3 багц төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгахад гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж, санхүүжилтийг гэрээний дүнгээр олгосон байна. /Хүснэгт 2.2/

Хүснэгт-2.2

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээнд заасан хугацаа		Хүлээн авсан огноо
		Эхлэх	Дуусах	
1	Багц-1 Сайхан-Овоо сумын ЗДТГ-т автомашин Лексус 470	2015.10.06	2015.11.06	2015.11.16
2	Багц-1 Сайхан-Овоо сумын ЗДТГ-т автомашин УАЗ Пургон	2015.10.23	2015.11.23	2015.11.23
3	Багц-2 Сумдын засаг даргын тамгын газарт автомашин нийлүүлэх	2015.11.04	2015.11.20	2015.11.30
4	Багц-3 Цагдаагийн газарт автомашин нийлүүлэх	2015.11.18	2015.12.10	2015.12.09

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн автомашинуудын ашиглалтын байдалтай танилцахад автомашинуудыг ашиглаж байгаа боловч хувийн хэрэг нээж хөтлөөгүй байна.

НББ, Шилэн данс

Аудитаар хүлээн авсан төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн дүнг НББ, шилэн дансанд тусгасан дүнтэй тулгаж үзлээ. Гүйцэтгэлийн дүнгээр нийт 284,589.8 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг хүлээн авсныг НББ-д үнэн зөв тусгасан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймгийн ТЕЗ болон аймгийн төвийн байгууллагууд хөрөнгө оруулалтын талаарх мэдээллээ бүрэн байршуулсан байна. /Хавсралт №6/

Хүснэгт-2.3

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хүлээн авсан гүйцэтгэлийн дүн /мянган төгрөг /	НББ-д тусгагдсан дүн /мянган төгрөг/
1	Сумдын засаг даргын тамгын газарт автомашин нийлүүлэх Багц-2	199,889.8	199,889.8
2	Цагдаагийн газарт автомашин	10,000.0	10,000.0
3	Багц-3 Сайхан-Овоо сумын ЗДТГ-т автомашин Лексус 470	49,500.0	49,500.0
4	Багц-3 Сайхан-Овоо сумын ЗДТГ-т автомашин УАЗ Пургон	25,200.0	25,200.0
<b>Нийт</b>		<b>284,589.8</b>	<b>284,589.8</b>

**Зөрчил 2.2** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд сумдууд мэдээллээ оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.3.7-д /хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;/, 6.2.4-д /хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт;/ заасныг тус тус зөрчсөн байна. Зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтнуудад хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

### Улсын төсвийн хөрөнгө оруулалт

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь МУ-ын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдсан байна.
2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.
3. Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн боловч зарим ажлууд дутуу хийгдсэн байна.
4. Их засварын ажлын гүйцэтгэлд тавьж буй зохиогчийн хяналт тухай бүр хийгдэхгүй байна.
5. Төсөл, арга хэмжээг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй,
6. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймгийн төвийн байгууллагаас бусад нь хөрөнгө оруулалтын ажлыг мэдээлээгүй байна.

### Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийг зөрчиж баталсан байна.
2. Эрх шилжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.
3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ гэрээний дагуу хэрэгжсэн байна
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгасан ч сумдууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд энэ талаарх мэдээллийг оруулаагүй байна.

### *ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ*

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийг аудитаар ҮАГ-т дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. МСҮТ-ийн хичээл дадлагын байр, спорт заал, дотуур байрны барилгыг улсын комисс хүлээн авсан боловч ашиглаж эхлээгүй, санхүүжилт дутуу зэрэг асуудлуудыг БСШУЯ, Хөдөлмөрийн яамнаас тодруулах.

### *ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ*

Өмнөх аудитаар Аймгийн засаг даргад 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, хөрөнгийг бүртгэл тайлагналд тавих хяналт хангалтгүйгээс зарим төсөл арга хэмжээг бүртгээгүй буюу зөрүүтэй бүртгэсэн байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

### **Аймгийн Засаг дарга-д:**

1. Дэрэн, Баянжаргалан сумдын цагдаагийн кабоны барилгын баримт материалыг Аймгийн архивт шилжүүлэх саналыг ЦЕГ-т уламжилж шийдүүлэх
2. Цаашид гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд ил тод байдлыг хангаж ажиллах, хариуцлагын талаарх заалтыг тусгаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөлөө.

### **ГХБХБГ-д**

3. Үе шатны ажил бүрт зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх,
4. Ажил бүрт ил далд ажлын актыг гаргуулан авч баталгаажуулж байх
5. Барилгын ажлын явцад зураг төслөөс өөрчлөгдөн гүйцэтгэсэн ажилд гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулж байх

ТАЙЛАН БИЧСЭН:

ШИНЖЭЭЧ  
ШИНЖЭЭЧ

Ч.БЭРХСАЙХАН  
Т.ЭНХНАРАН



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР


Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-ò çààñí ù ààãóó àóäèèòù í тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж, санал òàééáàððù äàâëàà.



АЙМГИЙН АУДИТЫН  
ГАЗАР

*Түвшээболор*  
*Сайсан*  
*Машаан тайвч*  
*М.Оюу*

гэрэлтүүлэгч ажлын төсөвт тусгагдаагүй. Мөн спорт заалны гэрэлтүүлгийн ажил төсөвт байгаагүй нэмэлтээр 6 ш заалны гэрэлтүүлэг угсарсан. Спорт заалны ханын шавардлагын элсэн ширхэгүүд суларч хөндийрсөн учир хананд затирка татаж эмульсэн будгаар будах ажил нь үр дүнгүй. Иймд вакуум цонхы резин, нугас, түгжээ солих ажлын өртгийг шавардлагын элсэн ширхэгүүд суларч, хөндийрсэн хэсгийг шавардахаар ашиглагч, гүйцэтгэгч байгууллагатай хурлын тэмдэглэл хөтлөн өөрчилсөн болно. Ажлын зурагт дулааны үзелийн өрөөнөөс барилгын баруун талын халаалтын шугам, радиаторыг солихоор тусгагдсан. Дулааны уэль дээр бусад хуучин шугамыг холбохоор тусгасан байна.



Шинээр хийсэн Ф50мм –ийн халаалтын өгөх шугам

Танай 2016 оны 103 тоот албан тоот бичгийн хариуг хүргүүлж байна.

Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэхалбаны цагдан хорин байр, Дэрэн сумын цэцэрлэгийн гадна шугам сүлжээ, зуухны барилга барилга байгууламжийн баримт бичгийг архивт шилжүүлсэн байна. / Архивын тасгийн албан тоотыг хавсаргав/ Баянжаргалан, Дэрэн сумдын цагдаагийн кабоны ажлыг аймгийн ГХБХБГ-ын даргын тушаалаар батлагдсан комисс хүлээн аваагүй болно. Иймд баримт бичиг нь цагдаагийн ерөнхий газарт байгаа.
2. Барилга байгууламжийн баталгаат хугацааны туршид мэдээллийн самбар байрлуулахыг шаардах, хэрэгжүүлж ажиллах гэдэг нь гүйцэтгэлийн баталгаат хугацаа юм уу, чанарын баталгаат хугацаа юм уу гэдэг нь тодорхойгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.3 –т " Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна" гэж заасан байна. Хуулийн 46.1.9-д заасан баталгаат хугацааг гүйцэтгэлийн баталгаат хугацаа гэж ойлгож байна. / МСҮТ-ийн хичээл дадлагын байр, спорт зал, дотуур байрны барилга байгууламжийн гадна бохирын шугамын ажил дуусаагүй учир мэдээллийн самбар байж байгаа болно. Бусад ажил дуусаж улсын комисст хүлээлгэн өгсөн болно /
3. МСҮТ-ийн хичээлийн байр, дадлагын байр, спорт зал, дотуур байрны барилга угсралтын ажилд нийт 96 ил далд ажлын акт үйлдсэн болно. Туршиж шалгасан акт нь 25 байна. Баримт материалыг төрийн архивт хүлээлгэн өгсөн. Далд ажлын актыг санхүүжилтийн баримт бичигт хавсаргаагүй болно. Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар батлагдсан " Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.5-ийн дагуу санхүүжилтийг олгож баримтийг архивласан болно.
4. Хулд сумын сургуулийн барилгад шинээр 4 ламптай гэрэлтүүрэгч-152 ширхэг, 2 ламптай гэрэлтүүлэгч 49 ширхэг угсрахаар зураг төсөвт тусгагдсан нь хуучин гэрэлтүүлгийн кабелийн үзүүрээс шалтгаалан зураг зааснаар угсрах боломжгүй байсан тул төсвөөс зөрүүтэй гэрэлтүүлгийн сургуулийн захиргаанд хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн, шатны 2

5. Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлын төсөвт цонх солих ажил байхгүй ашиглагч байгууллага саналаар гүйцэтгэгч байгууллага 2 ширхэг цонх хийсэн. Шатны талбай дээр байрласан халаалтын секц нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах боломжгүй учир радиаторыг өрөөнүүдэд нэмэлж угсарсан байна. Ажлын зурагт тусгагдсан угаалтуур, суултуур, душ, трап хийх ажлын төсөвт өртгөөр ажлыг эрхлэгчийн өрөөний хаалга, хана, шал, таазны ажилд шилжүүлэн хийсэн байна. Цэвэр усны шугам нь 2-р давхараар түгээж зургаас өөрчилсөн нь ажлын тоо хэмжээ болон ажлын төсөвт өртөгт нөлөөлөхгүй юм. Үүнээс гадна нэмэлтээр цэцэрлэгийн барилгын коридорын 257 м<sup>2</sup> гадаргууг эмульсэн будгаар будсан, 54м<sup>2</sup> бетон талбай цутгасан, 259,8 м<sup>2</sup> шалыг хулдааспсан байна.
6. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн болон нийцлийн аудитыг хийх явцад тухайн хөрөнгө оруулалты газар дээр нь үзэж танилцахдаа барилгын мэргэжлийн хүмүүсийг багтаа авч ажиллуулж байх саналыг хүргүүлж байна.

ЗАСАГ ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ





ажилд гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулах гэсэн зөвлөмж хүргүүлсэн.

Тайланд Хулд сумын сургууль, Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлууд зураг төсвийн дагуу хийгдээгүй, зарим ажлуудыг өөрчилж хийсэн байна гэж байсныг Хулд сумын сургууль, Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засварын зураг төслөөс өөрчлөгдөн гүйцэтгэсэн ажилд гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулаагүй байна гэж өөрчиллөө. Хүснэгт 1.6-д өөрчлөлт орууллаа.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/6

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Гүйцэтгэлийн шалгалтын журмын 23 дугаар зүйлийн 2, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан ҮАГ-ГАГ/2016/01-ГА-г баталсугай.

Хоёр. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөгжлийн бодлогын хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба -д тус тус хүргүүлсүгэй.


Дөрөв. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2016 оны 05 дугаар сарын 25-ны дотор Аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Од-Эрдэнэ/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/-д тус тус зөвлөсүгэй.

Тав. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2016 оны 3 дугаар улиралд гарган танилцуулахыг Аудитын менежер /Б.Гантуяа/, Гүйцэтгэлийн аудитын багийн шинжээч /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ







**АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Аудитын код: ҮАГ-ГАГ/2015/01-ГА

Аудитын нэр: “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн мян.төг	Үүнээс				Үр өгөөжийн	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
	Бүртгэлд аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, зөрүүтэй тусгасан	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын” журмын 5.1	866.7			866.7		1	866.7
1	Үе шатны ажил бүрд ил, далд ажлын акт гаргуулан авч баталгаажуулаагүй	Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Засгийн газрын 77-р тогтоолоор батлагдсан барилга захиалагчийн дүрмийн 3.1.2	255.7				255.7	1	255.7
2	Үе шатны ажил бүрт зохиогчийн хяналт гүйцэтгүүлээгүй	Засгийн газрын 73-р тогтоолоор батлагдсан Барилга захиалагчийн дүрмийн 3.1.7, Монгол улсын дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан “Барилгын норм ба дүрэм батлах тухай /барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм/”-ийн 1.3	185.7			185.7		1	185.7
3	Барилгад хувийн хэрэг нээгээгүй, их засварын өөрчлөлтийг хувийн хэрэгт хөтлөөгүй	Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 71 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх” журмын хавсралт 1-ийн 1.2, 1.3	10,377.3			1,266.9		1	10,377.3

4	Зураг төслөөс өөрчлөгдөж гүйцэтгэсэн ажил бүрт гүйцэтгэлийн зураг боловсруулж баталгаажуулаагүй	Барилгын тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.7	185.7		185.7		1	185.7	
5	Хөрөнгө оруулалтын ажлыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй	Шилэн дансны тухай хуулийн 6.3.7, 6.2.4	10,706.6		10,706.6		1	10,706.6	
6	Мэдээллийн самбар байрлуулаагүй	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.9	2,523.5			2,523.5	1	2,523.5	
7	Худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо босго үнийг баримтлаагүй	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 68-р тогтоол	75.0		75.0		1	75.0	
8	Зураг төсвийн дагуу ажлаа бүрэн гүйцэтгээгүй байхад хүлээн авсан	Барилгын тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.7, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга захиалагчийн дүрмийн 3.1.4, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт барилгын төсөв зохиох дүрмийн 3-р бүлгийн 3.4, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын" журмын 3.3	298.6		298.6		1	298.6	
9	Барилга байгууламжийн баримт материалыг архивт шилжүүлээгүй	Барилгын тухай хуулийн 21.2-д /Хөрөнгө оруулагч, захиалагч нь ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын гүйцэтгэлийн акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын чанар, явцад зохиогч болон мэргэжлийн хяналт гүйцэтгэгчийн дүгнэлт, ашиглалтад хүлээлгэн өгсөн баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 1 сарын дотор холбогдох архивт шилжүүлнэ./	1,303.6			1,303.6	1	1,303.6	
<b>Дүн</b>			<b>26,778.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>22,695.6</b>	<b>4,082.8</b>	<b>9.0</b>	<b>26,778.4</b>

АУДИТЫН ГАЗАР



ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн төсөл, арга хэмжээ-Дундговь аймаг

Монгол улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, байгууллагын стратеги төлөвлөгөө	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил /2015/
		Дэрэн сумын цэцэрлэгийн гадна шугам сүлжээ уурын зуухны барилга
Хүн амын орон сууцны хангамж, дэд бүтцийг сайжруулж, хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлнэ.		Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт
	Цагдаагийн кабоны барилгыг 2-оос доошгүй суманд барьж, цагдаагийн алба хаагчдын ажиллаж амьдрах нөхцлийг сайжруулна.	Дэрэн, Баянжаргалан сумдын цагдаагийн кабон
Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэл, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргийг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.	Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн хэлтсийн албаны байр, цагдан хорих байрууд болон бохирын шугамыг засварлана.	Шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрын барилга
Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.	Хулд сумын сургуулийн барилгад засвар хийх.	Хулд сумын сургуулийн барилгын засвар
	Өлзийт сумын цэцэрлэгийн барилгад засвар хийх.	Өлзийт сумын цэцэрлэгийн барилгын засвар

	МСҮТ-ийн хичээл, дадлага, спорт заал, дотуур байрны барилгыг ашиглалтад оруулна	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн байр, дадлагын байр, спорт зал 960 суудал / Дундговь, Сайнцагаан / Дундговь аймгийн "Мэргэжил сургалт үйлвэрлэлийн төвийн дотуур байрны барилга барих" ажил
Эрүүл мэндийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглахыг дэмжинэ.	Өндөршил сумын ЭМТ-ийн барилгад засвар хийх	Өндөршил сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар
	Адаацаг сумд стандартын шаардлага хангасан шинэ барилга барьж ашиглалтанд оруулах	Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн барилга
	ЭМГ-т стандартын шаардлага хангасан шинэ оффисийн барилга барьж ашиглалтанд оруулах	Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга
Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.	Сайхан-Овоо сумын Дотуур байр, Эрдэнэдалай, Луус сумдын Цэцэрлэг, Баянжаргалан, Гурвансайхан сумдын сургуулийн барилгыг ашиглалтад оруулна.	Гурвансайхан сумын сургуулийн барилга

## Хавсралт №2

## Дундговь аймгийн БСШУГ-ын төсвийн төсөлд өгсөн санал

№	Байгууллагын нэр	Хийгдэх ажил	Төсөвт өртөг	Зураг төсөв хийгдсэн эсэх	Засварын ажил хийгдсэн эсэх
1	Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэг	Барилгын их засвар	250,482,000.00	тийм	хийгдсэн
2	Хулд сумын Сургууль	Барилгын их засвар	300,252,000.00	тийм	хийгдсэн
3	Говь-Угтаал сумын Сургууль	Барилгын болон сантехникийн засвар	199,862,000.00	тийм	хийгдээгүй
4	Сайнцагаан сум 4-р цэцэрлэг	Барилгын их засвар	210,448,000.00	тийм	хийгдээгүй
5	Сайнцагаан сум 1-р цэцэрлэг	Барилгын их засвар	154,563,000.00	тийм	хийгдээгүй
6	Цагаандэлгэр сумын Сургууль	Хичээлийн байрны болон спорт залны дээврийн засвар	80,000,000.00	тийм	хийгдээгүй
	<b>Дүн</b>		<b>1,195,607,000.00</b>		

№	Байгууллагын нэр	Хийгдэх ажил	Төсөвт өртөг	Зураг төсөв хийгдсэн эсэх	Ажил хийгдсэн эсэх
1	Мандал сургууль/ шинэ 960 /	Гадна ариутгах татуургын ажил	92,800,000.00	тийм	хийгдээгүй
2	Мандал сургууль /шинэ 960 /	Спорт зал	805,000,000.00	жишиг зургаар холболт хийх	хийгдээгүй
3	Дэрэн сумын Хүүхдийн цэцэрлэг	Уурын зуухны барилга, гадна шугам сүлжээ	304,963,000.00	тийм	хийгдсэн
4	Баянжаргалан сум Хүүхдийн цэцэрлэг	100 ортой цэцэрлэг	905,000,000.00	тийм	хийгдээгүй
5	Адаацаг сум ЕБС	Дотуур байр /80 ор /		Зураг төсөв хийлгэж байгаа	хийгдээгүй

6	Дэлгэрцогт сумын ЕБС	Хичээлийн байр /240/		Зураг төсөв хийлгэж байгаа	хийгдээгүй
7	Сайнцагаан сумын Цэцэрлэг	150 ортой шинээр барих		жишиг зургаар холболт хийх	хийгдээгүй
	<b>Дүн</b>		<b>2,107,763,000.00</b>		

Хавсралт №3

2015 онд шинээр хэрэгжиж эхэлсэн аймагт эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны талаар

Д/д	2015 онд эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний нэр	Хаана эрх шилжиж ирсэн	Эрх шилжүүлсэн		Тендерт оролцогчдын тоо	Хэдэн удаа тендер шалгаруулсан эсэх	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Гэрээ байгуулсан огноо
			ТЭЗ	Шийдвэрийн дугаар, огноо					
1	Сургуулийн барилгын засвар /Дундговь, Хулд/	Аймгийн засаг даргад	БСШУС	2015.02.10-ны 1а/1061 Албан бичиг	7	1	Нээлттэй	2015.06.02	2015.06.10
2	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Өлзийт/	Аймгийн засаг даргад	БСШУС	2015.02.10-ны 1а/1061 албан бичиг	6	1	Нээлттэй	2015.07.23	2015.07.30
3	Эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Өндөршил/	Аймгийн засаг даргад	ЭМСС	2015.05.15-ны 201 тушаал	2	1	Нээлттэй	2015.04.14	2015.04.21
4	Гурвансайхан сумын дэд бүтцийн ажлын дуусгалт	Аймгийн засаг даргад		2015.06.19-ны 3/2031			Гэрээ үргэлжлүүлэх	2015.06.15	2015.06.22

**ХААА-д төсөл арга хэмжээний тендерт оролцогчдын ерөнхий мэдээлэлээ ирүүлсэн байдал**

№	Тендерт оролцогчдын нэр	Ерөнхий шаардлага			Санхүүгийн шаардлага				Техникийн шаардлага				Үнийн санал
		Тусгай зөвшөөрөлтэй эсэх /хуулбар/	Улсын бүртгэлийн гэрчилгээтэй эсэх /хуулбар/	Аудитлагдсан санхүүгийн тайлан	Хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жагсаалтаар ирүүлсэн эсэх	Шүүх, татварын хэлтсийн тодорхойлолт	Банкны зээлийн баталгааны тодорхойлолт	Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн ажлын туршлага /жагсаалтаар/	Инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй эсэх /хуулбар/	Гэрээт ажилд ашиглах машин, тоног төхөөрөмжийн гэрчилгээтэй эсэх /хуулбар/		
<b>Хулд сумын сургуулийн барилгын засвар</b>													
				2014 оны санхүүгийн тайлан	Сүүлийн 1 жил		30 сая төгрөгөөс багагүй байна	БО-н хэмжээ 50 сая /сүүлийн 1 жил/					
1	Гурван дэлгэр ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	30 сая		тийм	тийм		95,025,383.00	
2	Баянгийн говь ХХК	тийм	тийм	тийм	тийм	үгүй	40 сая	223.5	тийм	тийм	тийм	91,700,000.00	
3	Билдхаус ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	30 сая		тийм	тийм	тийм	97,301,734.00	
4	Гарденсити ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	40 сая	925.7	тийм	тийм	тийм	91,198,950.00	
5	Дөл БГМ ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм			тийм	тийм	тийм	97,034,085.00	
6	Их түмэн эрдэнэ ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	50 сая	679.0	тийм	тийм	тийм	95,274,040.00	
7	Мандал хүрээ ХХК	тийм	тийм	тийм		тийм			тийм	тийм	тийм	93,752,850.00	
<b>Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын засвар</b>													
				2013, 2014 оны санхүүгийн	Сүүлийн 2 жил		80 сая төгрөгөөс багагүй	БО-н хэмжээ 80 сая /сүүлийн					



				тайлан			байна	2 жил/				
1	Дар нүдэн ХХК	тийм	тийм	тийм				171.0		тийм	тийм	95,642,850.00
2	Тааны амт ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	94,454,212.00
3	Дөл БГМ ХХК	тийм	тийм	тийм		тийм				тийм	тийм	90,999,000.00
4	Гурван дэлгэр ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм /натари отаар баталг аажуул аагүй/	тийм			тийм	тийм	92,275,116.00
5	Баянгийн говь ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм			тийм	тийм	91,070,000.00
6	Баян мараат ХХК	тийм	тийм	тийм	тийм		тийм			тийм	тийм	98,410,187.00
<b>Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засвар</b>												
				2012, 2013, 2014 оны санхүүгийн тайлан	Сүүлийн 2 жил		БО-н хэмжээ 50 сая төгрөгөөс багагүй байх	БО-ын хэмжээ 100 сая /сүүлийн 2 жил/	Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлыг өртөг 100 сая төгрөгөөс багагүй байх			
1	Гурван дэлгэр ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		383.1	тийм	тийм	тийм	131,985,210.00
2	Говийн булаг ХХК	тийм	тийм	тийм		тийм	50 сая			тийм		138,926,087.00
<b>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр автомашин худалдан авах /багц-2/</b>												
		Тусгай зөвшөөрөлтэй эсэх /хуулбар/	Улсын бүртгэлийн гэрчилгээтэй эсэх	Сүүлийн 2 жил	Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жагсаалтаар ирүүлсэн эсэх	Шүүх, татварын хэлтсийн тодорхойлолт	Багцын үнийн дүнгийн 50%-иас доошгүй	Борлуулалтын хэмжээ сүүлийн 2 жилийн дундаж тендерт оролцогчдын үнийн	Сүүлийн 2 жил		Техникийн тодорхойлолт ирүүлсэн эсэх	

			/хуулб ар/					дүнгийн 50%-иас доошгүй				
1	Эй Кэй Юу ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	110 сая	256.5	тийм		тийм	199,889,800.00
2	Эдмоор ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм		397.5	тийм		тийм	199,909,000.00

Тендерт шалгарсан оролцогчдыг өнгөөр ялгасан болно.

МСҮТ-ийн хичээл, дадлагын байрын барилгын хана цуурсан байдал



Хаалганы хана, барилгын гадна хана хэсгээр хагарсан байдал





Хичээл, дадлагын байрын паар хагарсан байдал



Дотуур байрны өрөөнүүдийн паар хагарч ус гоожсон байдал



**НББ-д болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тусгасан байдал /сая төгрөгөөр/**

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хүлээн авсан гүйцэтгэлийн дүн	НББ-д тусгагдсан дүн	Шилэн дансанд тусгагдсан дүн
1	МСҮТ-ийн хичээл дадлагын байр, дотуур байр	9,019.8	1,398.7	0
2	Сургуулийн барилгын засвар /Дундговь, Хулд/	91.2	91.2	0
3	Цэцэрлэгийн барилгын засвар /Дундговь, Өлзийт/	94.5	94.5	0
4	Эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Өндөршил/	70.0	ажил дуусаагүй	0
5	Гурвансайхан цэвэрлэх байгууламж	260.0	0	0
	Дүн	9,535.5	1,584.4	0
<b>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт</b>				
1	Сумдын засаг даргын тамгын газарт автомашин нийлүүлэх Багц-2	199.9	199.9	199.9
2	Цагдаагийн газарт автомашин	10.0	10.0	10
3	Сайхан-Овоо сумын ЗДТГ	75.0	75.0	0
	Дүн	284.9	284.9	209.9
<b>Эрх шилжиж ирээгүй төсөл арга хэмжээ</b>				
1	Эмнэлэгийн барилга, 10 ор / Адаацаг /	861.1	861.0	0
2	Эрүүл мэндийг дэмжих төв / Сайнцагаан /	759.2	759.2	759.2
3	Цэцэрлэгийн гадна шугам сүлжээ уурын зуухны барилга / Дэрэн /	305.0	0	0

4	Сургуулийн барилга / Гурвансайхан /	2,605.5	801.6	0
5	Шийдвэр гүйцэтгэх алба / Сайнцагаан /	841.8	841.8	841.8
6	Баянжаргалан сумын Цагдаагийн кабон	80.0	78.1	78.1
7	Дэрэн сумын Цагдаагийн кабон	79.5	78.7	78.7
	Дүн	5,532.1	3,420.4	1,757.8
	<b>Нийт дүн</b>	<b>15,352.50</b>	<b>5,289.70</b>	<b>1,967.70</b>